

ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР ОЮУТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

(Ховд их сургуулийн жишээн дээр)

Т.Буяндэлгэр

Ховд их сургууль

tbuyandelger.mn@gmail.com

Хураангуй

Судалгаанд оюутны сэтгэл ханамжийг тодорхойлох болон цахим сургалтад хамрагдахад тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох 16 асуулт бүхий асуумжийн хуудас ашигласан ба нийт 147 оюутныг хамруулан судалсан. Оюутнуудын сэтгэл ханамжийг Ликертийн 5 онооны хэмжүүрээр тодорхойлоход 4.68 байв. Оюутны сэтгэл ханамжийн түвшинд цахим сургалтад хамрагдаж буй дамжаа болон суралцаж буй хөтөлбөрөөс хамааран статистикийн ач холбогдол бүхий ялгаа байлаа. Цахим сургалтад хамрагдахад хамгийн ихээр тулгамдаж буй асуудлуудад интернэтийн хэрэглээ, технологийн дутмаг байдал болон интернет орох дата худалдаж авах нь эдийн засгийн хувьд хүндрэлтэй, цахим сургалтын агуулга их, даалгавар гүйцэтгэх хугацаа бага, эргэх холбоо сул, багаар болон хамтран ажиллах боломж хязгаарлагдмал зэрэг асуудлууд нэрлэгдсэн байна.

Түлхүүр үг: Цахим сургалт, Цахим хичээл, Цахим сургалтын агуулга.

Оршил

Олон улсад цахим сургалтын хэлбэрийг сонгох суралцагчийн тоо жил ирэх тутам нэмэгдэж, сургалтын байгууллагууд энэ чиглэлийн программ хангамж, платформуудыг эрчимтэй хөгжүүлж цахим болон танхимийн сургалтыг хослуулан явуулах хандлага их нэмэгдэж байна. Танхимын сургалттай харьцуулахад цахимаар сургалт явуулахад суралцагчаас хариуцлага, сурах зорилгоо ухамсарласан байдал зэрэг хувийн чадвар, сахилга бат ихээхэн шаарддаг онцлогтой. Цаг үеийн шаардлагад нийцүүлэн Ховд их сургууль сургууль нь 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлын сургалтын үйл ажиллагааг 100% цахим хэлбэрээр, 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлын сургалтын үйл ажиллагааг хосолсон хэлбэрээр зохион байгуулж, сургалтын 36 хөтөлбөрөөр 1476 гаруй оюутан цахим сургалтын үйл ажиллагаанд оролцож байна. Нийт оюутнуудын 3.1 хувь нь хотын төв, 49.2 хувь нь аймгийн төв, 16.6 хувь нь сумын төв, 31.1 хувь нь багийн төв болон хөдөөнөөс судалгаа авах үед цахим хичээл судлаж байсан байна. Судалгааны ажлын хүрээнд цахим сургалтын үйл ажиллагааны талаар оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлон тэдэнд

тулгарч буй бэрхшээлүүдийг илрүүлэхийг зорилоо.

Үндсэн хэсэг Ховд Их Сургуулийн оюутнуудаас тоон ба чанарын судалгааны аргаар судалгааг авсан болно. Судалгаанд тус сургуулийн сургалтын 36 хөтөлбөрөөр суралцаж буй 1476 оюутнаас 147 оюутан хамрагдсан байна. Судалгааг нийт 16 асуулт бүхий асуумжаар 2020 оны 10-р сарын 14-нөөс 29-ны өдрүүдэд GoogleForm ашиглан цахим хэлбэрээр зохион байгууллаа. Судалгааны өгөгдөл мэдээлэлд MS EXCEL болон SPSS программ ашиглан дүн шинжилгээ хийсэн.

Зорилго


Цахим сургалтын зохион байгуулалт, явцын талаар оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлон тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх

Зорилт

- Цахим сургалтын үйл ажиллагааны талаар оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох
- Цахим сургалтын явцад оюутнуудад тулгарч буй бэрхшээлийг тодруулах


Судалгааны үр дүн

Цахим судалгаанд зөвхөн бакалаврын хөтөлбөрийн оюутнууд хамрагдсан байна. Оюутнуудыг суралцаж буй дамжаагаар авч үзвэл 78.8 хувь нь 1 ба 2-р дамжаанд суралцагсад оролцсон байна. Оюутнуудын 72.8 хувь нь цахим сургалтын үйл ажиллагаанд оролцох нөхцөл бүрдсэн хотын болон аймгийн төвд, 27.2 хувь нь хувь нь баг, хөдөөнөөс цахим сургалтанд оролцож байна.




Зураг 1. Цахим хичээл судлах интернет орчин бүрдсэн байдал

Судалгаанд хамрагдсан оюутнуудаас цахим хичээлийг хоцрогдолгүй судлах интернэт орчин бүрдсэн эсэхийг тодруулахад 63.3 хувь буюу 93 оюутан нь цахим хичээл судлах интернэт орчин хангалттай бүрдсэн, 28.6 хувь буюу 42 оюутан нь дунд зэрэг бүрдсэн, 8.2 хувь буюу 12 оюутан нь цахим хичээл судлах цахим орчин нөхцөл бүрдээгүй гэж хариулсан байна.



Зураг 2. Оюутнуудын цахим хичээл судлахад зарцуулж буй хугацаа

Судалгаанд оролцсон оюутнуудын 31.3 хувь нь цахим онол, дадлага семинарын хичээл судлах, даалгавар гүйцэтгэхэд өдөрт 3 болон түүнээс дээш цагийг зарцуулж байгаа ба энэ нь оюутнуудад бие даан суралцах чадвар, өөрийгөө хөгжүүлэх чадварууд давхар төлөвшиж буйг харуулж байна.



Зураг 3. Цахим хичээл судлахад ашиглаж буй хэрэгсэл

Цахим онол, дадлага семинарын хичээл судлах, даалгавар, бие даалт гүйцэтгэхийн тулд судалгаанд оролцсон нийт оюутнуудын дийлэнх 78.2 хувь нь гар утас, 44.9 хувь нь компьютер ашиглаж байгаа ба бусад ipad болон бусад гэсэн хариулт өгөөгүй байна. Энэ нь дэлхий нийтэд гар утасны хэрэглэгчдийн тоо их байдаг судалгааны үр дүнтэй нийцэж байна.



Зураг 4. Цахим хичээл судлахад тулгарч буй бэрхшээл

Судалгаанд хамрагдсан оюутнуудаас цахим хичээлийг судлахад ямар бэрхшээл тулгарч буйг тодруулахад 46.3 хувь нь интернэт орчин муу, 38.8 хувь нь ямар нэгэн бэрхшээл байхгүй, 15 хувь нь цахим хичээл судлах техник хангамж буюу компьютер, ухаалаг утас муу байна гэж хариулсан байна.

Хүснэгт 1. Цахим сургалтын талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин

Асуулт	Дундаж
Цахимаар илгээсэн лекц, дадлага, семинарын хичээлүүдийн агуулгыг бүрэн ойлгож мэдлэг, ур чадвар эзэмшиж байгаа эсэх	4.69
Багш нар цахимаар илгээсэн хичээлтэй холбоотой унших материал, нэмэлт мэдээлэлээр хангаж байгаа эсэх	4.71
Цахим дадлага, семинарын хичээлийн даалгаварууд нь бие даан гүйцэтгэх боломжтой байгаа эсэх	4.62
Цахим хичээлтэй холбоотойгоор багш нар арга зүйн зөвлөгөө, тайлбар зааварчилгаа дэмжлэгийг хэрхэн үзүүлж байгаа эсэх	4.67
Цахим бие даалт, даалгавар гүйцэтгэх хугацаа хангалттай байгаа эсэх	4.68
Хичээлтэй холбоотой эх сурвалж мэдээлэлийг цахим орчиноос олж авч ашиглаж байгаа эсэх	4.71
Цахим хичээлүүдийн аудио, видео материалуудын дуу чанартай эсэх	4.88
Цахим хичээлүүдийн аудио, видео материалуудын дүрс чанартай эсэх	4.90
Цахим хичээлүүдийн аудио, видео материалуудын текст чанартай эсэх	4.86
Дундаж	4.68

Цахим сургалтын үйл ажиллагааны талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн үзүүлэлтээс харахад цахим сургалтыг зохих түвшинд зохион байгуулж чадсан байна гэж үзэж болхоор байна.

Хүснэгт 2. Оюутнуудын сэтгэл ханамж, түүний хамаарлын үр дүн

	Оюутны тоо	Дундаж	Стандарт хазайлт	95% итгэх интервал утга		Р утга
				Доод утга	Дээд утга	
Оюутны сэтгэл ханамжийг ангиар харуулсан байдал						
1-р анги	57	3.7279	.67214	3.4531	4.0026	0.26
2-р анги	30	3.8549	.80432	3.6074	4.1024	
3-р анги	31	3.8376	.75683	3.5337	4.1415	
4-р анги	29	4.0097	.76827	3.7351	4.2843	
Оюутны сэтгэл ханамж мэргэжлийн чиглэлээс хамаарсан байдал						
Инженерийн боловсрол	17	3.9278	.74121	3.7424	4.1131	0.01
Багш байгалийн ухааны боловсрол	55	4.1815	.67862	4.0644	4.2986	
Багш нийгмийн ухааны боловсрол	48	3.8075	.74183	3.5830	4.0320	
Багш бус мэргэжлийн ангиуд	27	3.3643	.71376	3.1035	3.6251	

Хүснэгт 2-аас харахад цахим сургалтад хамрагдаж буй оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин оюутны цахим хичээл судлаж буй мэргэжлийн чиглэлээс ($p=0.01$) үзүүлэлтийн хувьд статистик ач холбогдол ажиглагдсан бол оюутнуудын суралцаж буй дамжаа ($p=0.26$) ач холбогдолгүй байна.

Цахим лекц, лаборатори, семинарын хичээлийн талаар оюутнуудаас авсан нээлттэй асуулгад нийт 77 оюутан хариулсан ба хариултыг дараах агуулгаар багцалж 131 хариулт авсан байна.

Хүснэгт 3. Цахим сургалтын талаарх нээлттэй асуултын үр дүн

Үзүүлэлт	Оюутны тоо	Хувь
Цахим хичээл ойлгомжтой, сайн, боломжийн гэсэн эерэг хариулсан	35	45.5%
Байнга дата худалдаж авах хэрэгцээ гардаг, эдийн засгийн хувьд хүндрэлтэй байна	27	35.1%
Нэг дор олон даалгавар өгдөг, даалгавар хийх хугацаа бага	19	24.7%
Техник хэрэгсэл хангалтгүй /компьютер байхгүй, байнга утсаар үзэж байна/	14	18.2%
Багш нартай эргэх холбоо тогтоох хэрэгтэй /Асуух зүйл гардаг, даалгавар шалгаж байх, зөвөлгөө өгдөг байх/	11	14.3%
Оюутан өөрөө хичээвэл болно, Цаганд хэмнэлттэй, хаанаас ч сурах боломжтой	8	10.4%
Даалгавар гүйцэтгэх заавар ойлгомжгүй	7	7.8%
Багш өөрөө ярьж видео хэлбэрээр хичээл бэлдэж өгөх нь үр дүнтэй	5	6.5%
Цахим хичээлээр мэдлэг, чадвар эзэмшихэд хүндрэлтэй	3	3.9%

Цахим сургалтын онцлог нь суралцагч сурах зорилгоо ухамсарласан, суралцах хүсэл, хувийн хариуцлагатай байхыг онцгойлон шаарддаг. Цахим сургалт болон танхимийн сургалт хосолсон холимог сургалтын арга зүйг оновчтой хэрэгжүүлэх замаар цахим сургалтын сул тал, сөрөг үр дагаваруудыг даван туулах боломж бүрдэх юм.

Боловсролын чанарыг сайжруулахад цахим сургалтын программ хангамж платформ хөгжүүлэх эсвэл бэлэн хөгжүүлсэн байгаа системийг сонгон авч багш оюутан хоёуланд нь суралцах боломжийг бүрдүүлэн, системд хандах эрх, дата болон бусад нийгмийн асуудлыг дэмжиж нэгдсэн зохион байгуулалтад оруулан сургалт явуулах нь чухал байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

- Цахим сургалтын үйл ажиллагааны талаарх оюутны сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 4.68 байна. Энэ нь Ховд их сургууль мультимедиа студи, зайн сургалтын төв, мэдээллийн технологийн хөгжлийн төв байгуулан ажиллаж байгаатай холбоотой гэж судлаачийн зүгээс үзэж байна. Сэтгэл ханамж нь оюутны суралцаж буй мэргэжлийн чиглэлээс ($p=0.01$) хамааран статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Оюутны сэтгэл ханамжид цахим сургалт явуулах бэлтгэл, нөгөө талаас оюутны өөрийн цахим орчинд суралцах арга барил мөн цахим сургалтын хэрэглэгдэхүүний чанарыг илүү сайжруулах шаардлагатай нь харагдаж байна.

- Цахим сургалт зохион байгуулах туршлага бага, оюутнуудын цахим сургалтад хамрагдахад бэлэн биш байдал зэрэг нь багагүй хүндрэлүүд үүсгэж байгаа ч, цахим сургалтад мөн цөөнгүй боломж, давуу талууд байдгийг онцолж байна.

Abstract

Currently, the term e-Learning is widely used, meaning the process of learning in electronic form via the Internet. The study was conducted using cross sectional study design and qualitative and quantitative methods. Then we aimed to assess student satisfaction on the eLearning and reveal some factors on it. A Total of 147 students answered a questionnaire to assess student satisfaction on eLearning. The questionnaire contained totally 16 questions. Mean satisfaction was 4.68 and main influencing factors was the course of students, curriculum. Learning curriculums are influenced on student satisfaction statistically significant (p value is lower than 0.05). The most occurred problems faced with students when they attend on eLearning insufficient internet connection, quality of e-lessons and no experience on attending to e-lessons. Then we need to improve the quality of e-lessons, increase speed of internet connection for improving student satisfaction. It is crucial to detect student satisfaction on the eLearning for further development of eLearning.

Зохиогчийн тухай

Төмөр-Очир овогтой Буяндэлгэр, ОХУ-ын Эрхүү хотын Техикийн Их Сургууль төгссөн, Ховд Их Сургуулийн Байгалийн шинжлэл, Технологийн Сургуулийн Математик, Мэдээлэлзүйн тэнхимийн Багш, Магистр, Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем, Цахим сургалтын чиглэлээр судалгаа хийдэг. tbuyandelger.mn@gmail.com

Ном зүй

- Наранчимэг Н., Төгөлдөр Э., 2014. Боловсролын удирдлага, УБ,
- Пүрэвдорж Ч., 2013. Багшлахуйн менежмент УБ,
- МУ-ын Дээд боловсролын тухай хууль.
- Байгалмаа Ч., 2009. Багшийн хөгжлийн практик. УБ,
- Батхуяг С., Төртогтох Б., Цогзолмаа Н., 2019. Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник, УБ,
- Зайны сургалтын хөтөлбөр. <https://www.distancelearningportal.com/countries/>